



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Баян-Өндөр сумын Сум хөгжүүлэх сангийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2022 /9/ НА-СТА-ОНТС

Цахим хуудас:

www.audit.mn

Орхон аймаг

2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах

Утас:70359826

Цахим хаяг:orkhon@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ

Утас:70355805

Цахим хаяг:erdeneb@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Оргилмөрөн

Утас:70350757

Цахим хаяг:orgilmurung@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	5
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	6
3. Аудитын тайлан	7
3.1 Ерөнхий зүйл	7
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
3.4 Материаллаг байдал	8
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	8
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	9
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	10
3.8 Аудитын гол асуудал	10
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	10
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	10
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	10
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	11
4. Аудитын илрүүлэлт.....	11
4.1 Залруулсан алдаа	11
4.2 Төлбөрийн акт.....	11
4.3 Зөвлөмж	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ШШГГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
НББ	Нягтлан бодох бүртгэл



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.02.25 № 71
танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН БАЯН-ӨНДӨР
СУМЫН ЗАСАГ ДАРГА
Б.БААСАНСҮРЭН ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Баян-Өндөр сумын Сум хөгжүүлэх сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Баян-Өндөр сумын Сум хөгжүүлэх сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,086,497,870.34</u>	<u>1,122,643,815.11</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	144,028,852.34	270,362,518.23
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	144,028,852.34	270,362,518.23
3122	Гадаад валют	144,028,852.34	270,362,518.23
31221	Төрийн сангийн харилцах	144,028,852.34	270,362,518.23
33	АВЛАГА	941,970,018.00	851,782,296.88
335	Бусад авлага	941,970,018.00	851,782,296.88
3351	Байгууллагаас авах авлага	941,970,018.00	851,782,296.88
35	БАРАА МАТЕРИАЛ	499,000.00	499,000.00
354	Хангамжийн материал	499,000.00	499,000.00
35420	Аж ахуйн материал	499,000.00	499,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>712,500.00</u>	<u>62,500.00</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	712,500.00	62,500.00
393	Биет бус хөрөнгө	712,500.00	62,500.00
39301	Програм хангамж	1,950,000.00	1,950,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,237,500.00	-1,887,500.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,087,210,370.34</u>	<u>1,122,706,315.11</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>901,000,000.00</u>	<u>901,000,000.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	901,000,000.00	901,000,000.00
413	Өглөг	901,000,000.00	901,000,000.00
4136	Бусад өглөг	901,000,000.00	901,000,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	901,000,000.00	901,000,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>186,210,370.34</u>	<u>221,706,315.11</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	186,210,370.34	221,706,315.11
512	Хуримтлагдсан үр дүн	186,210,370.34	221,706,315.11
51210	Өмнөх үеийн үр дүн	151,915,832.17	186,210,370.34
51220	Тайлант үеийн үр дүн	34,294,538.17	35,495,944.77
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,087,210,370.34</u>	<u>1,122,706,315.11</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	44,601,138.17	48,635,944.77
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	44,601,138.17	48,635,944.77
120	Нийтлэг татварын бус орлого	44,601,138.17	48,635,944.77
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	44,601,138.17	48,635,944.77
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,231,592.80	31,290,194.03
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	28,369,545.37	17,345,750.74
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	10,306,600.00	3,140,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,306,600.00	3,140,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,306,600.00	3,140,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,306,600.00	3,140,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,656,600.00	2,490,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	650,000.00	650,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>34,294,538.17</u>	<u>45,495,944.77</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	10,000,000.00



225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	0.00	10,000,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	0.00	-10,000,000.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>34,294,538.17</u>	<u>35,495,944.77</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	165,334,828.34	165,334,828.34
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-13,418,996.17	-13,418,996.17
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	151,915,832.17	151,915,832.17
C07	Тайлант үеийн үр дүн			34,294,538.17	34,294,538.17
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	186,210,370.34	186,210,370.34
D01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	0.00	0.00	186,210,370.34	186,210,370.34
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	186,210,370.34	186,210,370.34
D08	Тайлант үеийн үр дүн			35,495,944.77	35,495,944.77
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	221,706,315.11	221,706,315.11

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>343,664,124.91</u>	<u>48,635,944.77</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	343,664,124.91	48,635,944.77
120	Нийтлэг татварын бус орлого	343,664,124.91	48,635,944.77
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	343,664,124.91	48,635,944.77
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	343,664,124.91	31,290,194.03
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		17,345,750.74
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>343,664,124.91</u>	<u>48,635,944.77</u>
14	Бусад эх үүсвэр	0.00	421,187,721.12
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх		421,187,721.12
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	323,656,600.00	343,490,000.00
230001	Эргэж төлөгдөх зээл	323,656,600.00	343,490,000.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>-323,656,600.00</u>	<u>77,697,721.12</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	20,007,524.91	126,333,665.89
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	124,021,327.43	144,028,852.34
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	144,028,852.34	270,362,518.23

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)



Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Дүн	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	408,140,000.00	343,490,000.00	64,650,000.0	84.2%
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	408,140,000.00	343,490,000.00	64,650,000.00	84.2%
230001	Эргэж төлөгдөх зээл	408,140,000.00	343,490,000.00	64,650,000.00	84.2%
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	408,140,000.00	469,823,665.89	-61,683,665.9	115.1%
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	408,140,000.00	48,635,944.77	359,504,055.2	11.9%
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	408,140,000.00	31,290,194.03	376,849,805.97	7.7%
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		17,345,750.74	-17,345,750.7	#DIV/0!
14	БУСАД ЭХ ҮҮСВЭР	0.00	421,187,721.12	-421,187,721.12	#DIV/0!
145005	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх		421,187,721.12	-421,187,721.12	#DIV/0!
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		144,028,852.34	-144,028,852.34	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		270,362,518.23	-270,362,518.23	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Орон нутгийн тусгай сан тул нэмэлт төсвийн дансгүй болно.

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Орхон аймгийн Баян-Өндөр сумын Сум хөгжүүлэх сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд бүртгэл санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Оргилмөрөн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон аймгийн Баян-Өндөр сумын Сум хөгжүүлэх сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/96 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Орхон аймгийн Баян-Өндөр сумын Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны чиглэлийг Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолд сумдад жижиг, дунд үйлдвэр шинээр байгуулах буюу үйл ажиллагааг нь өргөтгөх, шинэчлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлж, хөнгөлөлттэй зээл олгох гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомжид өөрчлөлт ороогүй байна. Харин Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолыг /Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам батлах тухай/ Засгийн газрын 2022 оны 81 дүгээр “Хоршооны хөгжлийг дэмжих талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолоор хүчингүй болгосон байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалын хавсралтаар “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ыг баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөг сайжруулах шаардлагатай байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон аймгийн Баян-Өндөр сумын Сум хөгжүүлэх сангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт хөрөнгийн дүн 1,123,171.3 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 22,463.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 17,970.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж аудитлагдсан санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийн дүнгийн өөрчлөлтэй холбоотой материаллаг байдлын дүн 9.3 мянган төгрөгөөр буурсан тул гүйцэтгэх үе шатанд материаллаг байдлыг 22,454.1 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Орхон аймгийн Баян-Өндөр сумын Сум хөгжүүлэх сангийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 35,495.9 мянган төгрөгөөр буюу 0.3 хувиар өссөн байна. Нийт хөрөнгийн өсөлт нь мөнгөн хөрөнгийн өсөлттэй холбоотой байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	144,028.85	270,362.52	126,333.67
Авлага	941,970.02	851,782.30	-90,187.72
Бараа материал	499.00	499.00	0.00
Үндсэн хөрөнгө	712.50	62.50	-650.00
Нийт хөрөнгө	1,087,210.37	1,122,706.32	35,495.94
Өр төлбөр	901,000.00	901,000.00	0.00
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	186,210.37	221,706.32	35,495.94
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,087,210.37	1,122,706.32	35,495.94

Мөнгөн хөрөнгө үлдэгдэл 270,362.5 мянган төгрөг болж 126,333.7 мянган төгрөгөөр өссөн нь зээлийн эргэн төлөлт, хүү, алдангийн орлоготой холбоотой байна.

Авлагын дансны үлдэгдэл 90,187.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 341,000.0 мянган төгрөгийн зээл шинээр олгосон ч нийт зээлийн эргэн төлөлт 421,187.7 мянган төгрөг тул авлага буурсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд өөрчлөлт ороогүй, үндсэн хөрөнгийн данс тайлант оны элэгдлийн зардлын дүнгээр буюу 650.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 35,495.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Орхон аймгийн Баян-Өндөр сумын Сум хөгжүүлэх сангийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 4,034.8 мянган төгрөгөөр буюу 9 хувиар өссөн байна. Өмнөх оноос орлого өссөн нь олгосон зээлийн хүүгийн орлогоос шалтгаалсан байна.

Нийт зардал өмнөх оноос 7,166.6 мянган төгрөгөөр буюу 69.5 хувиар буурсан байна. Энэ нь бараа үйлчилгээний бусад зардал буурсантай холбоотой байна.

Орхон аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар - 437 дугаар нээлттэй хорих ангийн 2021.10.21-ны өдрийн 03/1767 дугаар "Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дуусгавар болсон тухай" албан бичгээр шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад төлбөр төлөгч Ц нь 2021 оны 08 дугаар сарын 09-ний өдөр нас барсан, түүний өмчлөлд бусдад өвлөгдөх эд хөрөнгөгүй болох нь улсын бүртгэлийн байгууллагаас ирүүлсэн лавлагаагаар тогтоогдсон тул шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгосон болохыг мэдэгджээ.

Орхон аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 2109 дүгээр шүүгчийн захирамжаар иргэн Ц /ИО74121302/-с 15,107.7 мянган төгрөгийг гаргуулж Орхон аймгийн Баян-Өндөр сумын Сум хөгжүүлэх санд олгохоор шийдвэрлэснийг Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дуусгавар болсон тухай 2021.10.20-ны өдрийн 10/612 дугаар тогтоолоор 20140201 бүртгэлийн дугаартай гүйцэтгэх баримт бичигт явуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болсонд тооцсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Орхон аймгийн Баян-Өндөр сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн ээлжит II хуралдааны 08 дугаар тогтоолоор тус сангийн 2021 оны төсвийг зээл олголт 400,000.0 мянган төгрөг, үйл ажиллагааны зардал 8,140.0 мянган төгрөг буюу нийт зарлагыг 408,140.0 мянган төгрөгөөр тооцон баталж төсөвлөсөн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 72101 /Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих/ хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр Орхон аймгийн Баян-Өндөр сумын ИТХ-ын 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн ээлжит III хуралдааны 04 дүгээр тогтоолоор сум хөгжүүлэх сангийн орон тооны бус зөвлөл, хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн тогтоож, Орхон аймгийн Баян-Өндөр сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 37 дугаар тогтоолоор сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн материал хүлээн авах товыг 2021.05.21-2021.06.04-ны өдрийг дуустал хугацаагаар тогтоосон байна.

Орхон аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын 2021 оны А/135 дугаар захирамжаар "Сум хөгжүүлэх сан"-ийн төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн баталсан 26 иргэн, 6 аж ахуйн нэгжид нийт 341,000.0 мянган төгрөгийн зээл

олгохоор шийдвэрлэсэн байна. Тайлант онд үйл ажиллагааны зардалд 2,490.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 343,490.0 мянган төгрөг буюу 84.2 хувьтай байгаа нь үйл ажиллагаанд батлагдсан төсвийг 5,650.0 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан /хэмнэсэн/, зээл олгохоор баталсан төсвөөс 59,000.0 мянган төгрөгөөр бага зээл олгосонтой холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудит хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Орхон аймгийн Баян-Өндөр сумын Сум хөгжүүлэх сангийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 талбарын мэдээллээс хугацаандаа оруулсан 146 талбарын мэдээлэл, 5 талбарын мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Мөн цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 16.1 сая төгрөгийн 2 гүйлгээ, зарлагын 10.0 сая төгрөгийн 1 гүйлгээг дутуу мэдээлсэн байсныг нөхөж мэдээлэв.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зээлдэгч нарын зээлийн мэдээллийг Монгол банкны зээлийн мэдээллийн санд бүртгүүлэх талаар өгсөн 1 зөвлөмжийн биелэлт хангагдсан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Орхон аймгийн Баян-Өндөр сумын Сум хөгжүүлэх сангийн санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгөн шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй ба дараагийн аудитаар зээлдэгч нарын зээлийн эргэн төлөлтийг авч үзэж болох юм.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 34,299.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 10,464.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 21,333.0 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 2,501.2 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Үндсэн зээлийн эргэн төлөлтийн 464.9 мянган төгрөгийн орлогыг алдаатай бүртгэснээс авлагын үлдэгдлийг тус дүнгээр илүү илэрхийлсэн байна.
- Эргэн төлөгдөх боломжгүй болсон найдваргүй авлагын /Зээлдэгч нас барсан бөгөөд зээлдэгчийн өмчлөлд бусдад өвлөгдөх эд хөрөнгөгүй нь тогтоогдсон тул шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дуусгавар болсон тухай Орхон аймаг дахь ШШГГ-437 дугаар нээлттэй хорих ангийн 2021.10.21-ны өдрийн 03/1767 тоот албан бичиг/ 10,000.0 мянган төгрөгийг өмнөх үеийн үр дүн дансанд журнал бичилт хийсэн байна.

4.2 Төлбөрийн акт

1. Тус сангаас 2021 онд Төгс наян эгшиг ХХК-д хуралд оролцсон гишүүдийн 50 хувийн дэмжлэгээр /ердийн олонхын санал аваагүй/ 15,000.0 мянган төгрөгийн зээл олгосон ба эргэн төлөлтийг хасаад 2022.02.25-ны өдрийн байдлаар төлөгдөөгүй зээлийн үлдэгдэл 12,143.0 мянган төгрөг байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 4.4-д “... зөвлөлийн хуралд оролцсон гишүүдийн ердийн олонхын саналаар зохих шийдвэрийг гаргана. ...” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:Төлбөрийн акт тогтоов.

2. Баян-Өндөр сумын Сум хөгжүүлэх сангийн хяналтын зөвлөлд батлагдсан 800,000 төгрөгийг хувь хүний дансанд олгохдоо ХХОАТ-ын 80,000 төгрөгийг суутгаж олгоогүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 26.1.1-д “энэ хуулийн 11 дүгээр зүйл, 15.1-д заасан орлогын дүнд 23.1-д заасан хувиар, 14.1.1-д заасан орлогын дүнд 23.2.1-д заасан хувиар, 8.1.6, 8.1.7-д заасан орлогын дүнд 23.2.2-т заасан хувиар, 8.1.8-д заасан орлогын дүнд 23.2.3-т заасан хувиар тус тус албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх”, 26.3-д “Суутгагч нь албан татвар төлөгчийн орлогоос суутган авсан албан татварыг энэ хуулийн 26.1.6-д зааснаас бусад тохиолдолд дараа сарын 10-ны өдрийн дотор холбогдох төсөвт шилжүүлнэ” гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:Төлбөрийн акт тогтоов.

3. Тус сангаас 2021 онд иргэн Хүдэржаргалд хуралд оролцсон гишүүдийн 45.4 хувийн дэмжлэгээр 10,000.0 мянган төгрөгийн зээл олгосон байна. Сум хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн хуралд оролцсон гишүүдийн дийлэнх олонх нь 5,000.0 сая төгрөгийн зээл олгохыг дэмжсэн бөгөөд зээлийн эргэн төлөлтийг хасаад 2022.02.25-ны өдрийн байдлаар илүү олгосон зээлийн үлдэгдэл 3,055.0 мянган төгрөг,

Мөн иргэн Пүрэвдоржид төсөл сонгон шалгаруулах зөвлөлөөс 2,000.0 мянган төгрөгийн зээл олгох шийдвэр гарсан /тус иргэний ирүүлсэн төсөлд 2,000.0 мянган төгрөг хүссэн/ байтал 10,000.0 мянган төгрөг олгожээ. Зээлийн эргэн төлөлтийг хасаад 2022.02.25-ны өдрийн байдлаар илүү олгосон зээлийн үлдэгдэл 6,055.0 мянган төгрөг байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын 4.4-д "... зөвлөлийн хуралд оролцсон гишүүдийн ердийн олонхын саналаар зохих шийдвэрийг гаргана. ..." гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:Төлбөрийн акт тогтоов.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлагын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Зээлийн мэдээллийн сангийн программын бүртгэл дэх нийт зээлдэгч нарын зээлийн мэдээллийн дүнгээс санхүүгийн тайлангийн авлагын дүн 11.2 мянган төгрөгийн зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 4.4-д “Энэ хуулийн 4.1.3-т заасан стандартыг Төсвийн тухай хуулийн 4.1.34-т заасан байгууллага мөрдөнө” гэж заасантай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Оны эцэст зээлдэгч тус бүрээр тухайн онд төлсөн зээлийн хүү, алданги, үндсэн зээлийн эргэн төлөлтийг хянуулж, зээлийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулах. Санхүүгийн тайлангийн болон сум хөгжүүлэх сангийн зээлийн программын авлагын мэдээллийг тулган баталгаажуулах.

2. Зардлын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Санхүүгийн тайлан, тодруулга, тэмдэглэлийг сангийн сайдын холбогдох тушаалаар баталсан журмын дагуу иж бүрэн бэлтгээгүй. Мөн аккруэл болон мөнгөн суурьт шалгах баланс гаргаагүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2007 оны 326 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Төсөл, тусгай сангуудын санхүүгийн тайлан бэлтгэх заавар”-ын 3.2-д "Нэгтгэлийн зорилгоор төсөл, тусгай сан нь УСНББОУС-д нийцүүлэн гаргасан санхүүгийн тайланг аккруэль болон мөнгөн суурьт шалгах балансын /хүснэгт 1,2/ хамт харьяалах дээд шатны төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ", 8.4-д "Жилийн эцсийн санхүүгийн тайлан бүрэн тодруулгатай, улирлын тайлан зөвхөн өр авлагын талаар тодруулгатай байна" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2007 оны 326-р тушаалын 3-р хавсралтаар батлагдсан “Төсөл, тусгай сангуудын санхүүгийн тайлан бэлтгэх заавар”-ын 3.2-д болон 8.4-д заасныг хэрэгжүүлж ажиллах.

3. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Тайлант онд сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны зардалд батлагдаж, зарцуулсан 2,490.0 мянган төгрөгийг эргэж төлөгдөх зээл зардлын ангилалд зарцуулах эрхийг нээж зарцуулсан байна.

Энэ нь төсвийн тухай хуулийн 22.1-д "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", 22.2.3-д "эдийн засгийн ангиллаар", 37.1.8-д "төсвийн сар, улирлын хуваарьт үндэслэн төсвийн байгууллагын бүртгэлийн дансанд санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олгох" гэж заасантай нийцэхгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Үйл ажиллагааны зардлын санхүүжилтийн болон зарцуулалтыг эрхийг төсвийн сар, улирлын хуваарийн дагуу зардлын ангилал тус бүрээр нээж, хяналт тогтоох.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 05 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Орхон аймгийн Баян-Өндөр сумын Сум хөгжүүлэх сан	1	9,110.0			1	9,110.0				
2	Орхон аймгийн Баян-Өндөр сумын Сум хөгжүүлэх сан	1	12,143.0			1	12,143.0				
3	Орхон аймгийн Баян-Өндөр сумын Сум хөгжүүлэх сан	1	80.0			1	80.0				
4	Орхон аймгийн Баян-Өндөр сумын Сум хөгжүүлэх сан	1	11.2							1	11.2
5	Орхон аймгийн Баян-Өндөр сумын Сум хөгжүүлэх сан	1	0.0							1	0.0
6	Орхон аймгийн Баян-Өндөр сумын Сум хөгжүүлэх сан	1	2,490.0							1	2,490.0
7	Орхон аймгийн Баян-Өндөр сумын Сум хөгжүүлэх сан	1	10,000.0	1	10,000.0						
8	Орхон аймгийн Баян-Өндөр сумын Сум хөгжүүлэх сан	1	464.9	1	464.9						
Дүн		8	34,299.1	2	10,464.9	3	21,333.0	0	0.0	3	2,501.2